



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 08 дугаар сарын 29
№ 34 (1232)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 08 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн 3 дахь өгүүлбэрийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн 3 дахь өгүүлбэрийг хассугай.

Энэ хуулийг 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 03 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны
03 дугаар сарын 30-ны өдрийн 42 дугаар
зарлигийн хавсралт

ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД

№	Овог, нэр	Эрхэлж буй ажил	Албан тушаалын зэрэглэл	Олгох зэрэг дэв
1.	Нэргүйн Оюунчимэг	Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга	АА-3	Тэргүүн түшмэлийн дэд зэрэг
2.	Түдэвхүүгийн Гантулга	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга	ТЗ-14	Тэргүүн түшмэлийн дэд зэрэг
3.	Бямбасүрэнгийн Лхагва	Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга	АА-1	Тэргүүн түшмэлийн гутгаар зэрэг
4.	Батжаргалын Заяабал	Татварын ерөнхий газрын дарга	ТЗ-14	Тэргүүн түшмэлийн гутгаар зэрэг



5.	Батцэнгэлийн Энх-Амгалан	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга	AA-1	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
6.	Түндэвийн Жамбаажамц	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга	AA-1	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
7.	Баатарын Лхагвасүрэн	Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга	AA-2	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
8.	Лхагвын Лхагвасүрэн	Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн ахлах зөвлөх	AA-3	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
9.	Жамбалжавын Бямбадулам	Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх	AA-3	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
10.	Бямбаагийн Оюумаа	Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа арга зүйн хэлтсийн дарга	AA-3	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
11.	Бэлтрэгийн Цогбадрах	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга	AA-3	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
12.	Чандагын Бат-Эрдэнэ	Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга	AA-3	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
13.	Нямдоржийн Анхбаяр	Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга	T3-15	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
14.	Сандагдоржийн Батболд	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	T3-15	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Камбожийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лодойдамбын Галбадрахыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Камбожийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жамсрангийн Бямбасүрэнг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Кувейт Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зоригтын Чинтүшигийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Кувейт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Пүрэвийн Сэргэлэнг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Андоррын Хант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Авирмэдийн Баттөрийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Андоррын Хант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Уламбаярын Нямхүүг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 94 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Доржсүрэнгийн Алтаннавчийг Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 95 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Сүрэнхүүгийн Аюушжавыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 101 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Чойнорын Мөнгөнцэцэгийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 200003